

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УЦС	Усан цахилгаан станц
УТЗ	Урьдчилж төлсөн зардал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2020.03.13 № 06/828
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн олон жил болсон авлагыг барагдуулах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 22-ноос 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-д хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Акпар-Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 99 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн эрхэм зорилгыг Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хосолсон эх үүсвэрүүдээр тасралтгүй, найдвартай хангах гэж тодорхойлжээ.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хоёр аймгийн хэмжээнд хүрэлцэхүйц цахилгааны найдвартай эх үүсвэртэй болох,
- Системийн энерги алдагдлыг үе шаттайгаар бууруулах,
- Техник зохион байгуулалтын ажлын хэлтэс, ТЭЗҮ-ийн биелэлтийг хангаж, үр ашигтай ажиллах,
- Хүний нөөцийн чадавхыг сайжруулж, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх.

Чиг үүрэг:

- ЦДҮС-ээс авах цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх техник, технологийн шинэчлэлт хийх,
- Сэргээгдэх болон дулааны цахилгаан станц барьж байгуулах,
- Энергийн балансыг сар, жилээр гарган дүн шинжилгээ хийж, алдагдлын мөрөөр төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах,
- Сургалт, хөгжлийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ординат” ХХК-ийн “Винница” програм хангамж ашигладаг байна.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус компанийн дотоод аудитын алба нь 4 хүний орон тоотой ажиллаж байгаа ба 2019 онд толгой компани болон харьяа 4 салбарын хөрөнгийн ашиглалт хамгаалалт, 2019 оны их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд хийгдсэн ажил, төлөвлөгөөний биелэлт, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж, тодорхой заавар, зөвлөмж өгч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн болох 13,941.7 сая төгрөгөөс тооцон 139.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 123.6 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,167.6 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	451.9	306.4	-145.5
Авллага	461.2	1,167.6	706.4
Урьдчилж төлсөн зардал	313.8	287.3	-26.5
Бараа материал	3,415.7	2,310.6	-1,105.1
Үндсэн хөрөнгө	116,190.2	113,593.3	-2,596.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	120,832.8	117,665.2	-3,167.6
Богино хугацаат өр төлбөр	1,385.8	1,419.5	33.7
Урт хугацаат өр төлбөр	43,474.2	43,474.2	0.0
Өмч: Төрийн	60,388.0	60,388.0	0.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,635.7	16,635.7	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	21,948.8	22,219.3	270.5
Хуримтлагдсан ашиг	-22,999.7	-26,471.5	-3,471.7
ӨР ТӨЛБӨР / ӨМЧИЙН ДҮН	120,832.8	117,665.2	-3,167.6

Авллагын дансын үлдэгдэлд “Тайшир-Алтай ус төслийн барилга байгууламжийн цахилгаан хангамж”-ийн төслийн урьдчилгаа төлбөрийн болон тендерийн баталгааны 637.8 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний авлага 478.3 сая төгрөг, дотоодын байгууллагаас авах 51.5 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дүн өмнөх оны хэмжээнээс их хэмжээгээр буурсан нь 2018 оны эцэст “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-аас авсан 1,619.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг 2019 онд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгөнд Эрчим Хүчний сайдын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 68 тоот тушаалаар батлагдсаны 2019 оны худалдан авах ажиллагааны дагуу бэлтгэсэн 919.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Мөн 2018 онд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хөрөнгөөр Алтай-Улиастайн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг сайжруулах, төвийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллуулах техникийн боломжийг бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж техникийн комиссын шийдвэрээр АУЭХС компанид 897.9 сая төгрөгийн, Тайшир-Гуулин УЦС ХХК-д 322.9 сая төгрөгийн, Завхан салбарт 265.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг нийт 1486.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн худалдан авалтаас Тосонцэнгэл ХХК-д 3.4 сая төгрөг, Завхан салбарт 3.4 сая төгрөг, Богдын гол ХХК-д 1.7 сая төгрөг, Тайшир-Гуулин УЦС ХХК-д 0.6 сая төгрөгийн нийт 9.1 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн, гүйцэтгэх захирлын 2019 А/93 тоот тушаалаар актлан 0.3 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2018 оны 629 тоот тогтоолоор Богдын гол ХХК-д шилжүүлсэн 13.5 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Ашиглагдахгүй байгаа 131.7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг актлуулах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан бичиг хүргүүлсэн ч шийдвэр ирээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос дансны өглөг 12.9 сая төгрөг, бусад өглөг 8.2 сая төгрөгөөр тус тус буурсан ба улсын төсвөөс олгож байгаа татаасны орлогод НӨАТ тооцсон шалтгаанаас үүссэн татварын байгууллагад өгөх өр 207.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайширын усан цахилгаан станцыг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор 2000 онд “Кувейтийн сан” болон Эрчим хүчний удирдах газрын хооронд байгуулсан гэрээгээр 21.1 сая ам долларын зээлийг 22 жилийн, 2006 онд “Абу-Даби сан” болон “Эрчим хүчний судалгаа хөгжлийн төв”-ийн хооронд байгуулсан гэрээгээр 13.0 сая ам долларын зээлийг 20 жилийн хугацаатай авсан байна.

Монгол Улсын Их хурлын 2010 оны 72 дугаар тогтоолоор эдгээр зээлийг анх авсан үеийн ханшаар төгрөгт шилжүүлснээр 43.5 тэрбум төгрөг болсон ба компанийн төлбөрийн чадвараас шалтгаалан зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

2.9. Зорилтод түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эрчим хүчний сайдын 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 108 тоот тушаалаар Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант онд зорилтот түвшнээр 11,539.3 сая төгрөгийн орлоготой, 15,025.8 сая төгрөгийн зардалтай, 3,486.5 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоожээ.

2019 оны зорилтот түвшинд 76.0 сая/кВт/ц цахилгаан эрчим хүч боловсруулах төлөвлөгөөтэйгөөс 81.0 сая/кВт/ц ЦЭХ боловсруулсан нь төлөвлөгөөг 106.6 % биелүүлсэн. Энэ нь цахилгаан эрчим хүчний хэрэглээ өссөнтэй холбоотой юм.

Нийт хэрэглээний 50.7%-ийг худалдан авсан цахилгаан эрчим хүчээр, 49.3%-ийг дотоодын эх үүсвэрүүдийн үйлдвэрлэлтээр хангаж ажилласан байна.

Нийт 11,539.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 13,121.0 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 1,581.7 сая төгрөг буюу 13.7 хувиар давуулсан нь 2019 онд Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар өөрчлөлт оруулж 1 кВт цахилгаан эрчим хүчний үнэ ойролцоогоор 24 төгрөгөөр нэмэгдсэн мөн хэрэглээ 6.6%-аар өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт 16,592.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, батлагдсан зардал 1,566.9 сая төгрөгөөр хэтэрсэн нь цахилгаан эрчим хүчний худалдан авалт 6.6 хувиар өссөнөөс цахилгаан эрчим хүч худалдан авах зардал хэтэрсэн мөн хөрөнгө оруулалтын ажил 2.0 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал төлөвлөгөөт хэмжээнээс хэтэрсэнтэй холбоотой байна.

Төлөвлөгөөт алдагдлыг 3,486.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс 3,471.7 сая төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгөөт алдагдлыг 14.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Батлагдсан төлөвлөгөөгөөр 2019 оны жилийн эцэст нийт авлагын үлдэгдлийн дээд хэмжээг 250.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдлийн дээд хэмжээг 300.0 сая төгрөг байхаар

төлөвлөсөн боловч, 1,162.3 сая төгрөгийн авлагатай, 753.7 сая төгрөгийн өглөгтэй гарч, төлөвлөгдсөн хэмжээнээс авлагын үлдэгдлийг 912.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдлийг 453.7 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд шинээр эрсдэл нэмэгдээгүй ба нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,909.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,856.3 сая төгрөгийн алдааг залруулж, 53.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитын явцад дараах алдаа зөрчлийг залруулав. Үүнд:

- Тус компани дахин үнэлгээг “Бодит үнэ, цэнэ”-ээр бус “Бүрэн борлуулалтын өртөг” болон тооцоолж гаргасан элэгдлээр бүртгэлд тусгасан байна. Үүнээс болж 2019 оны эхний 3 улирлын элэгдлийг 3,028.3 сая төгрөгөөр илүү байгуулсан.
- Говь-Алтай аймгийн Бигэр сумын Өөшийн тариалангийн талбайд цахилгаан дамжуулах агаарын шугам татах дэд станц барих ажлыг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан концессын гэрээний дагуу хийж гүйцэтгэн, 2016 оны 4 дүгээр сард хүлээлгэн өгсөн ч ажлын хөлс болох 19.0 сая төгрөгийг төлөөгүй байсан.
- Тус компанийн охин компани болох “Богдын гол УЦС” ХХК-д техник, технологийн өөрчлөлтөөс болж, хоцрогдон, хэрэгцээгүй болсон 20.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг актлуулах арга хэмжээ аваагүй байна.
- Үндсэн хөрөнгийн шинжтэй 1,526.9 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн.
- Санхүүгийн тайлан дахь татварын үлдэгдэл Татварын цахим систем дэх үлдэгдлээс 210.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Худалдаж авсан үндсэн хөрөнгө болон суудлын автомашины сэлбэгийн 11.8 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөвт төлөх татвараас хассан байна.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон зарим ажиллагсдад олгосон урамшуулалд ыг 39.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулаагүй.

Аудитаар залруулагдаагүй 53.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус компани нь 43.5 тэрбум төгрөгийн урт хугацаатай зээлийн өртэй байгаа нь байгууллагын нийт эргэлтийн хөрөнгөнөөс 10.7 дахин их байна. Байгууллагын төлбөрийн чадвар, төлөх хөрөнгийн боломжоос хэд дахин давсан, төлбөр хийх хөрөнгийн ямар ч эх үүсвэргүй эдгээр зээлийг цаашид барагдуулах талаар дээд шатны захирагчид анхаарал хандуулах шаардлагатай байна.

Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хэмжээ санхүүгийн тайлан дахь дүнгээс 5,500.0 сая төгрөгөөр зөрүүтэй байгааг хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр байгааг дараагийн аудитаар авч үзэх асуудал гэж үзлээ.

Мөн нэгтгэл тайлангаар авлага, өглөгийн үлдэгдэл зорилтот түвшинд заасан хэмжээнээс хэтэрсэн нь зорилтот түвшнийг үндэслэлтэй баталж байхыг дээд шатны удирдлага, ТУЗ-ийн гишүүд анхаарах асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 425 мэдээллийг хуулийн хугацаанд, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмж хэрэгжих шатанд буюу зөвлөмжийн хэрэгжилт 85.7 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 53.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 123.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хуулийн дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

- 3.1.1 Илрүүлэлт: Тус компанийн авлагын дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн тайланд жилээс дээш насжилттай 53.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.
- 3.1.2 Эрсдэл: НББОУС 2-д “Авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр нь үнэлж тусгана” гэж заасан. Авлагын цэвэр боломжит үнийг нийт авлагын дүнгээс найдваргүй авлагын хасаж тооцдог тул дээрх стандарт зөрчигдсөн.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Дээрх авлагуудын төлөгдөхгүй байгаа шалтгааныг авлага бүрээр судалж, хариуцах эзэнгүй болсон авлагыг ТУЗ-ийн хуралд оруулан танилцуулж, хуулийн дагуу шийдвэрлүүлэх. Хариуцах эзэнтэй авлагыг зохих журмын дагуу хуулийн байгууллагад шилжүүлж, төлүүлэх арга хэмжээ авах.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Авлага барагдуулах талаар тодорхой график гарган ажиллаж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	451,924,376.20	306,403,956.06
1.1.2	Дансны авлага	430,800,101.28	1,162,085,094.22
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	19,790,768.71	5,294,896.47
1.1.4	Бусад авлага	10,635,264.00	227,500.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	3,415,659,745.55	2,310,624,477.38
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	313,787,532.11	287,283,129.19
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,642,597,787.85	4,071,919,053.32
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	111,404,762,455.61	108,546,390,989.85
1.2.2	Биет бус хөрөнгө	4,785,437,414.92	5,046,894,697.09
1.2.3	Биологийн хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	116,190,199,870.53	113,593,285,686.94
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	120,832,797,658.38	117,665,204,740.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	52,798,944.85	39,739,686.32
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	506,561,846.72	714,027,028.7
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	780,140,383.71	627,617,210.6
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	46,297,205.83	38,091,885.49
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,385,798,381.11	1,419,475,811.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	43,474,187,048.99	43,474,187,048.99
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	43,474,187,048.99	43,474,187,048.99
2.2	Өр төлбөрийн нийт дүн	44,859,985,430.10	44,893,662,860.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	60,388,037,164.58	60,388,037,164.58
2.3.2	- хувийн		

2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,635,666,439.18	16,635,673,045.77
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,948,832,209.34	22,219,282,209.34
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-22,999,723,584.82	-26,471,450,539.47
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	75,972,812,228.28	72,771,541,880.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	120,832,797,658.38	117,665,204,740.26

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	7,878,424,293.54	9,340,148,358.36
2	Борлуулалтын өртөг	11,410,682,450.79	15,025,819,040.70
3	Нийт ашиг(алдагдал)	-3,532,258,157.25	-5,685,670,682.34
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	32,801,889.91	10,352,058.67
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	2,256,165,494.63	3,008,568,434.46
9	Борлуулалт, маркетингийн зардал	49,154,095.10	88,775,667.34
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,283,646,848.62	1,039,564,081.29
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	198,182,153.80	393,806,272.62
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	6,200,000.00	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	1,477,340,725.54	718,204,461.67
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-2,290,733,144.69	-3,470,691,748.79
19	Орлогын татварын зардал	3,276,937.36	1,035,205.86
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-2,294,010,082.05	-3,471,726,954.65
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-2,294,010,082.05	3,471,726,954.65
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	1,503,964,488.14	18,975,469,815.51	-20,705,726,194.54	60,161,745,273.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				12,691.77	12,691.77
3	Залруулсан үлдэгдэл					0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-2,294,010,082.05	-2,294,010,082.05
5	Бусад дэлгэрэнгүй орлого					0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт			2,973,362,393.83		2,973,362,393.83
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		15,131,701,951.04			15,131,701,951.04
8	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	16,635,666,439.18	21,948,832,209.34	-22,999,723,584.82	75,972,812,228.28
9	Залруулсан үлдэгдэл					-
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-3,471,726,954.65	-3,471,726,954.65
11	Өмчид гарсан өөрчлөлт			270,450,000.00		270,450,000.00
12	Зарласан ногдол ашиг					-
13	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		6,606.59			6,606.59
14	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,388,037,164.58	16,635,673,045.77	22,219,282,209.34	-26,471,450,539.47	72,771,541,880.22

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,777,212,384.47	17,874,561,634.25
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,106,934,353.20	12,894,489,817.16
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	154,875.00	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	32,744,194.52	34,000,030.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		50,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	3,149,966,700.00	3,150,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,487,412,261.75	1,796,021,787.09
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,876,014,603.99	17,806,760,348.46
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,308,150,839.53	3,488,759,475.57
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	915,439,547.70	1,056,972,081.86
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,659,329,409.58	4,172,941,556.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	410,746,873.88	25,270,302.58
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,513,831,494.30	2,886,956,865.98
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	992,435,694.58	914,746,530.66
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	27,719,009.29	15,395,329.24
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,048,361,735.13	5,245,718,205.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-98,802,219.52	67,801,285.79
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	50,291,836.94	10,352,058.67
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	18,325,000.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	31,966,836.94	10,352,058.67
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	206,330,000.00	223,673,764.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	206,330,000.00	213,673,764.60
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,000,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-156,038,163.06	-213,321,705.93
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-254,840,382.58	-145,520,420.14
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	706,764,758.78	451,924,376.20
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	451,924,376.20	306,403,956.06

4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	хувь
	ЦЭХ-ний боловсруулалт	76.0	81.0	5.0	106.6
1	Худалдаж авсан ЦЭХ	41.1	41.1	0.0	100.0
	Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	34.9	39.9	5.0	114.4
2	Дотоод хэрэгцээний ЦЭХ	2.0	1.5	-0.5	74.5
3	Түгээлт ЦЭХ	75.3	80.4	5.1	106.8
4	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	22.0	22.1		0.07
	Борлуулах ЦЭХ	58.7	62.7	4.0	106.7
	Нийт орлого	11,539.3	13,121.0	1581.7	113.7
	Үүнээс: Борлуулалтын орлого	8,241.1	9,340.1	1099.1	113.3
5	Үйл ажиллагааны бус орлого	148.2	917.2	769.0	618.7
	Дизель түлшний санхүүжилт	2,150.0	1,954.5	-195.4	90.9
	Төсвийн санхүүжилт	1,000.0	909.1	-90.9	90.9
6	Нийт зардал	15,025.8	16,592.7	1566.9	110.4
	Үүнээс: Удирдлагын зардал	372.3	360.0	-12.4	96.7
7	Үндсэн үйл ажиллагааны ашиг / алдагдал /	-6,784.7	-7,252.6	-467.9	106.9
8	Татаасын орлого	3,150.0	2,863.6	-286.3	90.9
9	Цэвэр ашиг, /алдагдал /	-3,486.5	-3,471.7	14.8	99.6
10	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	1.3	1.3	0.0	97.1
11	Нийт ажиллагсадын тоо	332.0	332.0	0.0	100.0
12	Нийт авлага	250.0	1,167.6	917.6	0.0
13	Нийт өглөг	300.0	791.8	491.8	0.0
	Үүнээс: Богино хугацаат өглөг	300.0	791.8	491.8	0.0
14	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	1,239.8	1,035.9	-203.9	83.6
	Борлуулж буй ЦЭХ-ний дундаж үнэ	140.4	149.0	8.7	1.0
	Борлуулж буй ЦЭХ-ний өртөг	255.9	264.8	8.8	2.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.03.10			САГ-2020/63/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авлагын дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн тайланд жилээс дээш насжилттай авлага бүртгэлтэй байна.	53.1	Зөвлөмж өгсөн	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	А.Пүрэвсүрэн С.Ганзориг
	Нийт	53.1			

